

“ЗУД ЭСЭРГҮҮЦЭХ “ХӨДӨЛГӨӨН, ТҮҮНИЙ СУРГАМЖ”

Л. Чулуунбаатар

Товч утга: Энэ өгүүлэлд монгол оронд олонтаа тохиолддог байгалийн нэгэн гамшигт үзэгдэл болох зудын тухайд товч дурдахс, түүнийг хохирол багатай даван туулахын төлөө малчин түмнээс хэрхэн тэмцэж, ямар арга туршлага хүримтлуулсан талаар зарим санаа дүгнэлт хийхийг оролдоо. Манай ард түүний дунд зуд эсэргүүцэх гэдэг кампанит ажил их явагддаг байсан боловч өнөө үед түүнийг ойлгох, үнэлж асуудал үлэмж өөрчлөгдсөн байна. Тиймээс өнгөрсөн үеийн туршлага сургамжаас өнөө болон ойрын ирээдүйд санаа авах зарим бодол эргэцүүллийг товч тэмдэглэлээ.

Түүхүүр үг: Цас, хүйтэн, салхи, шуурга, нүүдэл

Өнө эртнээс өнөө хүртэл хүн төрөлхтний хийж чадаагүй нэгэн зүйл бол байгалийн элдэв үзэгдлийг удирдаж, гартаа оруулан захирч хүч хүрэхгүй байгаа явдал юм. Байгалийн үлэмж гамшиг учруулдаг ган, зуд эртнээс олон удаа тохиолдож байсан, зарим үед түүнээс нүүдэл хийх замаар зугатаж, заримдаа ихээхэн хохирол амсаж малчин ардууд хотоо харлуулж ирсэн ажээ. Харин хөдөө аж ахуйн нэгдлийн үед төв суурин газрын ажилчин албан хаагчид цаг уурын хүндрэл бэрхшээл тохиолдсон үед нэгдэлч малчиддаа тусlamж дэмжлэг үзүүлж, “зуд эсэргүүцэх”-ээр хөдөө орон нутагт ажиллаж байлаа. Энэ бол тэр үеийн нэг чухал кампанит ажил байсан. Өнөө үед зуд турхан тохиолдож байгаа боловч урьдынх шиг зуд эсэргүүцэхээ больсон бололтой юм. Зарим аймаг орон нутагт ган, зудын аюул нүүрлэж ирэхэд улсаас болон ард иргэд малын тэжээл, бэлэн бараа бүтээгдэхүүн илгээж, тусlamж үзүүлсэн болж байна. Ер нь “зуд эсэргүүцэх” гэдэг нэр томьёо нь өөрөө үлэмж зөрчилтэй, утга агуулга нь ихээхэн өөрчлөгдэж, энэ талаарх ойлголт янз бүрээр илэрхийлэгдэж иржээ. Тухайлбал, байгалийг хүн өөрөө захирч чадахгүй байгаа болохоор зуд эсэргүүцэх гэдэг нь угаасаа боломжгүй мэт, ойлгомжгүй утгатай атал социализмын үед “зуд эсэргүүцэх”, олон хүний ажил төрлийг тодорхой хэмжээгээр алдагдуулж ирсэн гэхэд нэг их хилсдэхгүй болов уу. Бас ниргэсэн хойно нь хашгирав гэгчээр байгалийн гамшиг нэгэнт тохиолдсон нөхцөлд улсаас их хүч хөрөнгө зарцуулж, олон хүний хөдөлмөр зүтгэлийг дайчилж, хохирлыг бага болгох гэж оролдож байсныг хүмүүсийн энгийн хэлж сурснаар “зуд эсэргүүцэх” хэмээн нэрлэж

хэвшижээ. Харин өнөө үед нийгмийн харилцаанд үндсэн өөрчлөлт гарч, нэгдлийн үе нэгэnt өнгөрсөн, ардын хувийн аж ахуйтнуудын өөрсдийн идэвх зүтгэл, уйгагүй хөдөлмөрөөс бүх зүйл шууд хамаарах болсон учраас зуд тохиолдоход олныг хамарсан нүсэр кампанит ажил явуулах уу, эсвэл түүний арга хэлбэрийг өөрчлөх үү гэсэн асуудал тулгарч байна. Чухамдаа энэ өгүүлэлд уг асуудлыг тойрч, өөрийн санаа бодлоо товч илэрхийлэхийг гол зорилт болголоо.

Судалгааны бүтээлүүдээс үзэхэд, манай оронд цагаан, хар, хүйтэн, шуурган, өлөн, шилэн (төмөр), хавсарсан гэх мэт олон янзын зуд болж байжээ. Өвөл маш их цас орж гачигдах цагийг цагаан зуд, өвөл цас орохгүй, хараар хүйтгэрч гачигдах цагийг хар зуд, идэш уушийн зүйл маш ховор цагийт өлөн зуд¹, гэдэг бол бас намар орой бороо орж, эрс хүйтэрсний улмаас бэлчээрийн өвс ургамлыг барьцалдан хөлдсөнийг шилэн буюу төмөр зуд гэж нэрлэдэг байна. Миний бие тус “Түүх” сэтгүүлд цувралаар байгаль цаг уурын нөхцөл, байгаль хамгаалалтай холбоотой олон өгүүлэл нийтлүүлсэн билээ. Тэдгээрийн дотор ган, зуд, нүүдэлтэй холбоотой өгүүллүүд бий².

Үндэсний Төв Архивт хадаглагдаж байгаа баримтуудын дотор Хөдөө Аж Ахуйн Яамны дансанд Онцгой комиссын илтгэл байдаг. Мал аж ахуйн удирдах газрын 1964 оны илтгэлд бичихдээ: “Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгууд хадлангийн төлөвлөгөөг 31- 40 хувиар тасалж, аймгийн фондод бүдүүн ба хүчит тэжээл бэлтгэх төлөвлөгөөг тасалдуулжээ. Хэрлэнбаян-Улааны отор тэжээлийн станц нь улсад үлэмж хэмжээний малын тэжээл бэлтгэх үүргээ маш хангалтгүй биелүүлсэн байна. Зуд болсон 9 аймгийн байдлаар авч үзэхүл өвс 46179, 6 тонн, хүчит тэжээл 1656,3 тонныг өвөл болж цагийн байдал хүндрээгүй байхад зарцуулсан байна. Өнгөрсөн зудын байдлаас үзэхэд, ихэнх аймгуудад хүйтний градус 50- 53 хэм хүрч, салхины чиглэл ямагт өөрчлөгдөж байснаас малын хашаа хороо цасанд дарагдан хэвтэр бууц хөлдөж мал осгож үхэх явдал их гарлаа. Манай улсын нутагт 1964 оны хоёрдугаар сарын 3- 22-ныг дуустал хугацаанд хойд туйлын онш хүйтэн агаар, БНХАУ-ын баруун хойд талын нутагт дундад өргөргийн харьцангуй дулаан агаар тогтвортойгоор байрлаж, эдгээрийн зааг дээр агаарын фронт үүсчээ. Энэ фронт дээр агаарын долгион бий болж, улмаар нам даралтын төв- циклон болон хөгжиж үе, үе хэвийн байдлаас хэтэрсэн их хэмжээний цас орсон байна. Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгийн зарим сумдаар 50- 60 см цастай байв. Мичин жилээр 32- 46 хэм байсан бол энэ жилийн хүйтний эрч хасах 48- 53 хэм хүрч байлаа. Говь- Алтай, Өмнөговь, Дундговь зэрэг 9 аймгийн 154 sumaас 104 сум, бүх малын 69 хувь буюу 8,5 сая мал зудад нэрвэгджээ.

-
1. Цэвэл. Я, Монгол хэлний товч тайлбар толь УБ., 1966, т.281.
 - 2.Чулуунбаатар.Л, Ган, зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд, Түүх- эрдэм шинжилгээний бичиг, № 188(14) УБ., 2002, т.99-103, Монголчуудын нүүдэллэлт, шалтгаан, сургамж , Түүх эрдэм шинжилгээний бичиг № 211(20), УБ., 2003.т.129-134.

Зуданд хамгийн их нэрвэгдсэн Говь-Алтай аймаг төлөө 68 хувь бойжуулж байхад, түүнээс арай хөнгөн хамрагдсан Баянхонгор аймгийн зудтай сумд төлөө 59 хувиар бойжуулж байна. 1964 оны зудаар учирсан хохирол нь зөвхөн 1,5 сая мал үхснээр тодорхойлогдох бус, харин зудын уршигаар олон сая мал турж доройтож, энэ хэрээр ашиг шим нь буурч, өвчин эмгэгт нэрвэгдэх үндсийг бий болгож, мал бэлтгэлийн ажилд хортойгоор нөлөөлж байна. Иймээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд, зудтай тэмцэх малчдын ажилд туслах, малын тэжээл бэлтгэх, тээвэрлэхэд туслах ажлаар 13200 хүнийг ажиллуулсан. Хотоос 850 гаруй, аймгуудаас 1600 ачааны авто машины цуваа гаргаж, нийтдээ 67600 машин өдөр ажиллуулсан. 2639,3 мянган төгрөгийн үнэ бүхий тэжээл олгосон байна. Зудын арга хэмжээтэй холбогдуулж нийтдээ улсаас 22 сая 668,2 мянган төгрөгийн зардал гарсан байна. Зудаар үхсэн том, жижиг малыг балансын дундаж үнээр үнэлж үзэхэд 30 гаруй сая төгрөгийн хохирол нэгдэл болоод нэгдлийн гишүүдэд учирч дээрхи 20 гаруй сая төгрөгтэй нийлүүлбэл 60 шахам сая төгрөгийн хохирол улсад учирчээ. Энэ үед ЗХУ-аас үзүүлсэн тусламж 10,4 сая төгрөг хүрч байв. Мичин жилийнхээс зудад гарзадсан малын тоо 4 дахин цөөн гарлаа³ гэжээ. Энэ зудаар мал сүргээ тоо толгой бүрэн авч гарсан малчид олон байжээ. Тухайлбал, “Баянхонгор аймгийн Баянцагаан сумын хоньчин Ёндонгийн Сүрэндуулам 45 хэмийн хүйтэн, цасан шуурганаар 10 хоногт хүнс, эм хэрэгсэл, загасны тос, тогоо шанага, сав, хүрз малтуур, дээл дэвсгэрээ тэмээндээ ачиж 700 малаа туугаад хөдөө ууланд гарч 3 бууц сэлгэж, цас малтаж чулуугаар 7 м урт хороо барьж 320 шахам цаг тэмцэж 13 хоноод хургалсан 7 хонины төлийг бүрэн бойжуулж, 707 малтай гэртээ эргэж ирсэн байна⁴. Бас архивын баримтанд,” Ган зудаас хамгаалахад улирлыг шинжих, хатуу бэрхийг үзэхгүй газрыг зааж, ардын малыг идээшлүүлэн бэлчээх тохь бүхий газар нүүдэллэх⁵ явдлыг чухалчлан тэмдэглэсэн байна.

1967-1968 оны өвөл хавар манай улсын 13 аймгийн 159 сумыг хамарсан зуд болж, улс орны эдийн засаг, ялангуяа мал аж ахуйд ихээхэн хохирол учруулсан билээ. Нэн ялангуяа Монголын баруун бүсийн аймгуудад өвөлжилт ихээхэн хүндэрч, зуд мал аж ахуйд асар их хохирол учруулж, малчдын мэдлэг чадвар, авхаалж самбаа, арга туршлагыг үлэмж шалгасан гэдэг. Тэр үед Говь- Алтай аймгийн Хар азаргын нуруу орчимд нутаглаж байсан хэдэн өрх айл зудын үед нэг ахмад малчныахаа зөвлөснөөр нүүдэл хийж, уулын орой тийш яваар нутаг орныхноосоо сураг тасран, Хар азаргын нурууны оройд гарсан байна. Гэтэл тэр өрх айлууд уулын орой дээр эрт үед малчид нутаглаж байсан бууцанд очиж, нэгэнт асар их цасанд боогдсон хэдий ч, мал хариулах ажилгүй, өнөтэй сайхан өвөлжжээ.

3. Үндэсний Төв Архив, ф. 15, д. 2, х.н. 196 ХААЯ. Онцгой комиссын илтгэл 1964, т. 4- 45.

4. Үндэсний Төв Архив, ф. 15, Д-1, ХН-3.Мал тариалангийн яамны дүрэм, аж ахуй, түүхэн лавлагаанд холбогдох тэмдэглэл 1930, т.34- 35.

5. Зудыг туулсан туршлага санамж УБ., 1970, т.55.

Учир нь уулын орой дээр салхины улмаас цас тогтохгүй, олон жилийн хур өвс сайтай, чоно нохой, элдэв айх зүйлгүй гэдгийг хашир өвгөн урьд өмнө настнуудаас сонссон болохоор өөрийн хот айлынхыг авч нүүдэл хийсэн ажээ. Харин тэр хот айлынхыг шуудангийн онгоцны жолооч олж харж, төвдөө мэдээ өгснөөр сураг тасарсан хүмүүсээ аймаг сумынхан мэдэж, онгоцноос тусламжийн гурил будаа тэргүүтнийг хаяж тусласан байна. Өвөл шувтарч, хавар болмогц тэр хот айлын хүмүүс нүүдэл хийж, нутаг буцья гэтэл өвгөн хориглож, цас бүрэн хайлсан хойно нутаг зүг явахыг зөвлөжээ. Энэ бол зудны дараа шар усны үер болно гэдгийг мэдэж, тэр аюулаас мөн хот айлынхыгаа аварсан хэрэг байв.

Энэ зудын үед “Говь-Алтай аймгийн Баян- Уул сумын хоньчин Мягмарын 7 настай охин Чунгаа, нийгмийн 500 гаруй хонийг өдөр шөнийн 24 цаг хээр тогтоон нэг ч малын хорогдолгүй хамгаалан авчээ. Мөн Говь-Алтай аймгийн Цогт сумын Төгрөг бригадын Өлзийбадарын Намжилмаа гэдэг 7 настай охин өнгөрсөн зудын үед цасан шуурга хүчтэй байсан өдөр Цагаан бяруутын гозгор гэдэг газар 30 шахам борлон эгц цавчим хаданд байцлагдсаныг үзээд бэрх тэр хаданд авирч 10 гаруйг гаргаад байтал шөнө болжээ. Шуурганы дунд 7 настай охин нэгдлийн 30 борлонг хадан хясаанаас гаргахын төлөө хүч тавин зүтгэсээр аргагүй хээр хонож хөлөө хөлдөөн зудын нэг шөнийг ийнхүү зориг баатарлагаар туулжээ.“ Энэ бүхнээс үзэхэд, “зуд эсэргүүцэх“ ажил юуны өмнө малчид, хөдөөгийн хүн амын өмнө хөгшин залуу, хүүхэд багачуудад ялгаагүй тулгарч, арга ухаан, авхаалж самбаа, хүч хөдөлмөрөө дайчлан зүтгэж иржээ. Дээр үеэс “зузаан малаас зуд зугатдаг“, “зун зудтай тэмц, зулзаган ногоо хураа“ гэх мэт настнууд сургаж, отор нүүдлийг их хийж, мал сүрэгтээ дээд зэргийн тарга хүч авахуулж ирсэн уламжлал нь угтаа “зуд эсэргүүцэж“, зудтай тэмцэж байсныг нотолж байгаа билээ. Энэ бол нүүдлийн мал аж ахуйн хамгийн хүнд хэцүү үе, нүүдэлчдийн ажил үйлсийг, оршин тогтонох, эсэхийг шалгасан хамгийн том сорилт шалгалтын цаг нь зун, намартаа ган, өвөл хавартaa зуд гэдгийг бүрнээ харуулж бүхий юм.

Өнгөрсөн зууны сүүлийн хагаст буюу хөдөө аж ахуйн нэгдлийн үед нийгмийн мал сүргийг зуд турхнаас хамгаалах асуудал нь бүх нийтийн үйлс байсан учраас өвөл хаварт цаг уурын өөрчлөлтийн улмаас цас их орж, эрс хүйтрэн зуд болоход аймаг, sumaас ажилчин албан хаагчид хөдөө орон нутагт малчдын суурьт очиж биеэр туслалцаа үзүүлэх, төлчнөөр ажиллах, албан байгууллагууд, төвийн оршин суугчид малын нэмнээ, гарын бээлий, лаа, шүдэнз, ер нь малчдад хэрэгтэй олон нэр төрлийн эд бараа, мөнгө хуримтлуулан бригад, сууриудад илгээж байлаа. Энэ бүхийг манай хүмүүс “зуд эсэргүүцэх“ гэж нэрлэж, энэ хөдөлгөөн нийт улс орныг хамарсан, өргөн олны сэтгэл зүтгэл шингэсэн ажил үйлс байжээ.

6. Малын зүй бус хорогдолтой тэмцэх явцад гарсан туршлага, санамж, зөвлөлгөө, УБ., 1976.т.22, 39.

Гэвч зарим малчид өөрсдөө мал сүргээ байгалийн гамшигт үзэгдлээс хамгаалах талаар санаачилга муутай, сум нэгдэлд бүхнийг даатгах хандлага гаргаж байжээ. Энэ талаар ном бүтээлд бичихдээ:" Малын зүй бус хорогдол гарч байгаа нэг шалтгаан нь хүмүүсийн ажлын хариуцлага, санаачилга, зохион байгуулалттай ихээхэн холбоотой байна. Ялангуяа өөрсдийн хариуцлага, санаачилга, зохион байгуулалтын ажил хангартгүй байснаас болж олон мал хорогдуулснаа "Зуд" гэж нэршсэн байгалийн бэрхшээл рүү түлхэж өөрсдөө дутагдлаа бүрхэгдүүлэн өнгөрүүлэхийг оролдох явдал зарим аймаг, сумын ажиллагаанд оршиж байгааг "Цаг агаарын хүнд байдлын улмаас мал аж ахуйд хохирол учрах явдлыг сэргийлж мал сүргийг онд бүрэн оруулах арга хэмжээний тухай" 1975 оны тогтоолд тодорхой заажээ⁷. Тэр ч байтугай социализмын үед эрх барьж байсан намын үзэл суртлаар, хүмүүсийн ухамсарт хуучин нийгмээс үлдэж хоцорсон " Зуд " бол малыг зайлшгүй үхүүлэх шалтгаан мэтээр ойлгодог буруу ойлголтыг арилгах ёстой, энэ нөхцөлд малын зүй бус хорогдлыг багасгахад ихээхэн чухал хүчин зүйл болно гэж үзэж байжээ. Гэсэн хэдий ч өнгөрсөн зууны үед манай орон даяар өрнөж байсан "зуд эсэргүүцэх" хөдөлгөөнөөс өнөө үед авах сургамж их байна.

Сүүлийн жилүүдэд ган, зудын давтамж ойртсон, хохирол үлэмж нэмэгдсэн аж. Тэгвэл одоо л "зуд эсэргүүцэх" гэдгийг жинхэнэ утгаар нь өрнүүлэх шаардлагатай бус уу. Энд юуны өмнө малчин ардын үе дамжсан мэдлэг ухааны ололтоос анхааран үзэх, өнөөгийн нөхцөлд бүтээлчээр баяжуулан хэрэглэх, амьдрах арга ухаанаа улам нарийсгах, ажилсаг, малч зүтгэлээр үйгагүй хөдөлмөрлөх хэрэгтэй юм. Манай малчид "сайн хавар цастай, муу намар бороотой", "ухаан байвал тэнгэрийн царай харахгүй, учраа олбол хүний царай харахгүй" гэж хэлцэж ирсэн нь бас "хаврын тэнгэр уйлсаар уйлсаар наашаа, намрын тэнгэр инээсээр инээсээр цаашаа" гэдгийг мартаж болохгүй гэж сургамжилж иржээ. Энэ нь "өвөл дараа дараагаар цас ихээр унаж, отгортгуйд олон солонго наран мэт тоонолжлон гарвал зудална" гэсэн хуучны сургаалыг санаж, малаа сайн таргалуул, өвөлжилтийн бэлтгэлээ эртнээс сайн ханга, хадлан тэжээл, хашаа хороо, нөмөр халх, хужир шүү, бууц хэвтгэр, ер юм болгоноо сайтар бэлд гэж байгалиас дохио өгч байна хэмээн үздэгтэй шууд холбоотой билээ.

Дүгнэлт, санаа

Эрт үеэс монгол оронд ган, зуд зэрэг байгалийн гамшиг олонтаа тохиолдож, малчин түмний арга ухаан, авьяас чадварыг сорьж шалгасаар ирсэн болохоор зудтай тэмцэх зузаан туршлага хуримтлагдаж, тэр нь үе дамжин уламжлагдаж иржээ. Дээр үед зудтай тэмцэх гол арга нь отор нүүдэл хийх, малдаа дээд зэргийн тарга хүч авахуулах явдал байв.

Малчид байгаль, газар орон, ус, цаг уурыг ямагт ажиглан шинжиж, ахуй амьдралдаа харгалзан үзэж, "тэнгэр унших" эрдэмд зэгсэн сайн суралцсан хүмүүс байжээ.

7.Д. Шагдарсүрэн Тэнгэр унших эрдэм УБ., 1991, т. 18- 19.

Тиймээс ч ажиглалт бол малчин хүний сургууль мөн гэж үзэж байв. Энэ уламжлал сүүлийн үед сүрхий суларсан, түүнээс үүдэн ган, зуд болсон хойно, өөрөөр хэлбэл ниргэсэн хойно хашгирав гэгчээр хөл алдан үймдэг болжээ. Үүний нэг илрэл нь өнгөрсөн зууны дунд үеэс буюу нэгдлийн үед “зуд эсэргүүцэх” гэдэг нийтийг хамарсан кампанит ажил улс орон даяар өрнөж ирсэн явдал билээ. “Зуд эсэргүүцэх” гэдгийг би хүмүүсийн ярианаас олон удаа сонсож, хөдөө малчны хотонд очиж туслалцаа үзүүлэх ажил явагдаж байхыг үзсэн төдийгүй, бас зарим нэгд нь оролцсон юм. Энэ нэр томьёо утга агуулгын талаар зөрчилтэй, уламжлалын үүднээс авч үзвэл, дээр үед хэрэглэгдэж байгаагүй, зөвхөн хамтын аж ахуйн үед л өргөн олны хүчийг ашиглах чиглэлээр гарч ирсэн байна. Манай малчин ардууд угаасаа зуд эсэргүүцэж, зунаас эхлээд мал сүргээ сайн таргалуулж, байгалийн гамшиг тохиолдсон нөхцөлд барьц алдаж сандарч байсангүй. Зудтай тэмцэж ирсэн малчдын туршлага бол асар арвин хийгээд их сургамжтай юм. Тэр арвин туршлагаас хураангуйлан хэлбэл, малчид цаг үргэлж тэнгэр уншиж, “зуны малыг зулайгаас нь, хаврын малыг хажуугаас нь, өвлүүн малыг өвдөгнөөс нь хамгаалж”, бас “дунд идэш, дулаан хэвтэр” хэмээн өтгө бууцыг чухалчилж, хадлан тэжээл, хашаа хороо, ус хужир зэргийг ихэд эрхэмлэж иржээ. Социализмын үед зуд гэдгийг хүмүүсийн ухамсарт хуучин ниймээс үлдэж хоцорсон ойлголт гэж үзээд, зуд болсон хойно түүнтэй эсэргүүцэн тэмцэж ирсэн өвөрмөц туршлага хуримтлагджээ. Миний бодлоор, одоо л харин “зуд эсэргүүцэх” гэдгийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх бүх талын боломж нөхцөл бүрдсэн мэт. Учир нь өнөө үед манай оронд ус цаг уур, орчны шинжилгээний ажил шинжлэх ухааны үндэслэлтэй явагдаж байгаа учраас ард иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэхээс гадна жил, улирал, сараар урьдчилан тооцоолж чадаж байна. Энэ ололтыг бодит амьдралд хүн бүр сайтар ашиглах хэрэгтэй болов уу.

“Зуд эсэргүүцэх” хамгийн гол арга бол малчин түмний хувьд бэлтгэл сайн байх, мал сүргээ сайн таргалуулж, малын хашаа хороо, хадлан тэжээлийг сайтар хангах, ус хужир, өтгө бууцыг ч нарийн тооцоолж ажиллах явдал юм. Байгалийн гамшиг бол хэлж ирдэггүй болохоор болзошгүй аюул тохиолдоход малчин түмэндээ цаг алдалгүй туслах төр, засаг, түмэн олны туслалцаа дэмжлэгийн ажлын менежментийг эрс өөрчилж шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна. Цаашдаа ч бид зудтай тэмцэж, байгалийн гамшигийг хохирол багатай даван туулах ёстай. Энэ бол монголчуудын оршин тогтонохиin төлөө тэмцэл гэж өргөн утгаар нь хэлж нэгэнт болно.

Abstract: This paper aimed to introduce the experience of the Mongolian cattle-breeders gained during their long life to overcome with minimal loss the zud, one of the natural calamities in harsh winter. In the socialist period, there were organised special campaigns to oppose the zud, however, nowadays their role is underestimated and their impact was not valued properly. Therefore it is advisable to learn some lessons from earlier experience.